



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Могод сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/006/НА-СА-ТТЗ

|                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                      |
|--------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас:<br><a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Булган аймаг<br>2025 он | Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a><br><br>Аудитор: А.Сувдаа<br>Утас: 70342495 Цахим хаяг: <a href="mailto:suvdaaa@audit.gov.mn">suvdaaa@audit.gov.mn</a> |
|--------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Аудитын санал, дүгнэлт



### БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.02.24 № 371  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

МОГОД СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Г.ЭНХБАТ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Могод сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Могод сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- ЖДҮДС-аас өмнөх оны авлага, өглөгийн үлдэгдэлгүй ч өвс, тэжээл борлуулсны орлого 15.3 сая төгрөгөөр давсан, тооцоо нийлсэн актгүйгээр 10.4 сая төгрөгийг 2022-2024 оны өвсний дутуу төлөлтийг шилжүүлсэн,
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 2 төсвийн шууд захирагч, 4 тусгай сангийн нийт материаллаг зөрчил зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20.2.5 Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.6, УСНББОУС 1, 2-той нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын

632502715

нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны XXV/05 дугаар тогтоол, сумын ИТХ-ын XVIII/01 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 43.8 хувиар өссөн байна.

### **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### **Бусад хэсэг**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 7 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2,556.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,136.5 сая төгрөгийг зарцуулж 419.9 сая төгрөгийг дутуу зарцуулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөг/

| Үзүүлэлт                                                 | 2023.12.31     | 2024.12.31     |
|----------------------------------------------------------|----------------|----------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>                         |                |                |
| Эргэлтийн хөрөнгийн дүн                                  | 896.8          | 882.1          |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн                              | 2,137.2        | 2,555.0        |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                | <b>3,034.0</b> | <b>3,437.1</b> |
| Нийт өр төлбөрийн дүн                                    | -              | -              |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн                                 | 3,034.0        | 3,437.1        |
| <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>               | <b>3,034.0</b> | <b>3,437.1</b> |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>                      |                |                |
| Үйл ажиллагааны орлогын дүн                              | 3,117.2        | 4,433.7        |
| Үйл ажиллагааны зардлын дүн                              | 2,651.7        | 4,013.2        |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН</b>                            | <b>465.5</b>   | <b>420.5</b>   |
| Үйл ажиллагааны бус үр дүн                               | 15.3           | 17.4           |
| Үйл ажиллагааны нийт үр дүн                              | 450.2          | 403.1          |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/</b>          |                |                |
| Дархин илэрхийлсэн үлдэгдэл                              | 2,583.8        | 3,034.0        |
| Тайлант оны үр дүн                                       | 450.2          | 403.1          |
| <b>ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ</b>                                   | <b>3,034.0</b> | <b>3,437.1</b> |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                          |                |                |
| Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                       | 2,947.2        | 3,959.3        |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн                      | 2,411.7        | 3,182.4        |
| Үйл ажиллагааны мөнгөн <b>ЦМГ</b>                        | <b>535.5</b>   | <b>776.9</b>   |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн                    | -              | -              |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн                   | 83.1           | 652.7          |
| Хөрөнгө оруулалтын <b>ЦМГ</b>                            | <b>(83.1)</b>  | <b>(652.7)</b> |
| Санхүүгийн үйл ажиллагааны <b>ЦМГ</b>                    | <b>(154.9)</b> | <b>(98.2)</b>  |
| Нийт <b>ЦМГ</b>                                          | <b>297.5</b>   | <b>26.0</b>    |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 287.8          | 585.3          |
| <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b> | <b>585.3</b>   | <b>611.3</b>   |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>                       |                |                |
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>                 |                | <b>2,136.5</b> |
| Урсгал зардал                                            |                | 1,410.1        |
| Хөрөнгийн зардал                                         |                | 628.2          |
| Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл               |                | 98.2           |
| <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>                    |                | <b>2,136.5</b> |
| Улсын төсвөөс санхүүжих                                  |                |                |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих                           |                | 1,805.4        |
| Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас                    |                | 239.1          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         |                | 467.9          |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        |                | 375.9          |

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх, зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

### Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ОНХС-аас нийт 27 төсөл арга хэмжээг баталснаас ТЭЗҮ болон төсвийн тооцоололгүй 210.5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйд өгч ажиллалаа.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1.Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг байршуулаагүйгээс дүнгээс хамаарч ЗДТГ, ИТХ, ХХС, ОНХС нийт 1,185.0 сая төгрөгийн 4 албан шаардлага өгч ажиллалаа.

### **Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

- Дараагийн аудитаар өглөг, авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй ч тайлант хугацаанд барагдуулсан болон санхүүжилт олгоогүй байх эсэхийг хянаж үзэх.
- ТЭЗ-ийн нэгдсэн тайланд тусгуулах: Зохих шатны шийдвэр, эрх зүйн үндэсгүйгээр аж ахуй нэгж байгууллагад сумын бэлчээр буюу өвсний гарц ихтэй газрыг түр хугацаанд ашиглуулан өвс бэлтгүүлэн 750 солоомыг ЖДҮДС-д үнэ төлбөргүй орлого авч иргэд, малчдад 7.5 сая төгрөгөөр борлуулж ЖДҮДС-д төлбөрийг төвлөрүүлсэн нь Газрын тухай хуулийн 6.2, 52 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

### **Зургаа. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1.2 сая төгрөгийн алдаа илэрснийг залруулж, 31.6 сая төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 28.8 сая төгрөгийн 3 албан шаардлага, 2.7 сая төгрөгийн 1 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 409.3 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 56.7 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 3.3 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 5.3 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 0.8 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн байна.

#### **6.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### **6.2 Албан шаардлага**

1. Сумын Байгаль хамгаалах зардлаас 3.1 сая төгрөгийн зориулалт бус зарцуулалт хийсэн нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт журмын 3.4, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.6-д “*төсвийг зориулалт бусаар зарцуулсан*” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

2. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санд өмнөх оны авлагын үлдэгдэл байхгүй ч тайлант онд нийт 43.5 сая төгрөгийн өвс, тэжээл зарцуулж 58.8 сая төгрөгийн өвсний мөнгө төвлөрсөн буюу 15.3 сая төгрөгийн илүү орлого орсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

3. Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих санаас өмнөх оны өглөгийн үлдэгдэл, тооцоо нийлсэн актгүйгээр 10.4 сая төгрөгийг аймгийн Мал хамгаалах сангийн 100040051410 тоот дансанд 2022-2024 оны өвсний дутуу үнийг шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, тасалбар болголт батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.7-д “*авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй*” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

### 6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгаль хамгаалах сангийн орлогыг бүрдүүлэхдээ гүйцэтгэлээр татварын орлогын дүнгээс /тогтоолоор баталсан хувиас илүү/ орох хувиас 2.7 сая төгрөгөөр илүү санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.6, ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт журмын 2.5, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан хувь хэмжээгээр санхүүгийн эх үүсвэр олгох, шаардлагатай тохиолдолд тодотголоор орлогын доод хувийг нэмэгдүүлж батлуулах

### Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

| Алдааны<br>товч утга | Нийт<br>алдаа |      | Мэдээллийг<br>тусгахгүй<br>орхигдуулсан |      | Буруу тусган<br>илэрхийлсэн |      | Үүнээс     |       |                   |     | Зөвлөмж |     |
|----------------------|---------------|------|-----------------------------------------|------|-----------------------------|------|------------|-------|-------------------|-----|---------|-----|
|                      |               |      |                                         |      |                             |      | Залруулсан |       | Залруу-<br>лаагүй |     |         |     |
|                      | Тоо           | Дүн  | Тоо                                     | Дүн  | Тоо                         | Дүн  | Тоо        | Дүн   | Тоо               | Дүн | Тоо     | Дүн |
| ЗДТГ                 | 2             | 9.2  | 1                                       | 1.15 | 1                           | 8.0  | 2          | 9.15  | 0                 | 0   | 0       | 0   |
| ИТХ                  | 2             | 42.3 | 1                                       | 5.20 | 1                           | 37.1 | 2          | 42.30 |                   |     |         |     |

|            |          |             |          |            |          |             |          |             |          |          |          |          |
|------------|----------|-------------|----------|------------|----------|-------------|----------|-------------|----------|----------|----------|----------|
| ХХС        | 2        | 5.2         | 1        | 1.88       | 1        | 3.3         | 2        | 5.20        |          |          |          |          |
| ТТЗ        | 1        | 1.2         |          |            | 1        | 1.2         | 1        | 1.20        |          |          |          |          |
| <b>Дүн</b> | <b>7</b> | <b>57.9</b> | <b>3</b> | <b>8.2</b> | <b>4</b> | <b>49.6</b> | <b>7</b> | <b>57.9</b> | <b>0</b> | <b>-</b> | <b>0</b> | <b>-</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил |             | Үүнээс        |             |                 |             |          |            |                                      |                     |                                                 |          |
|--------------------|-------------|-------------|---------------|-------------|-----------------|-------------|----------|------------|--------------------------------------|---------------------|-------------------------------------------------|----------|
|                    |             |             | Төлбөрийн акт |             | Албан шаардлага |             | Зөвлөмж  |            | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|                    | Тоо         | Дүн         | Тоо           | Дүн         | Тоо             | Дүн         | Тоо      | Дүн        | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо                                             | Дүн      |
| ЗДТГ               | 4           | 5.8         | 1             | 1.5         | 1               | 4.1         | 2        | 0.2        | 0                                    | 0                   | 0                                               | 0        |
| ИТХ                | 4           | 3.0         | 2             | 1.8         | 1               | 1.2         | 1        | -          |                                      |                     |                                                 |          |
| ХХС                | 1           | 0.7         |               |             |                 |             | 1        | 0.7        |                                      |                     |                                                 |          |
| ОНХС               | 0           | -           |               |             |                 |             |          |            |                                      |                     |                                                 |          |
| ТТЗ                | 4           | 31.5        |               |             | 3               | 28.8        | 1        | 2.7        |                                      |                     |                                                 |          |
| <b>Дүн</b>         | <b>13</b>   | <b>40.9</b> | <b>3</b>      | <b>3.28</b> | <b>5</b>        | <b>34.1</b> | <b>5</b> | <b>3.6</b> | <b>0</b>                             | <b>0</b>            | <b>0</b>                                        | <b>0</b> |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөг/

| Байгууллагын нэр                                         | Нийт зөрчил |                | Үүнээс        |          |                 |                |          |          |          |          |
|----------------------------------------------------------|-------------|----------------|---------------|----------|-----------------|----------------|----------|----------|----------|----------|
|                                                          |             |                | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                | Зөвлөмж  |          |          |          |
|                                                          | Тоо         | Дүн            | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн            | Тоо      | Дүн      | Тоо      | Дүн      |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |                |               |          |                 |                |          |          |          |          |
| ЗДТГ                                                     | 1           | 264.5          | 0             |          | 1               | 264.5          | 0        |          |          |          |
| ИТХ                                                      | 1           | 145.6          |               |          | 1               | 145.6          |          |          |          |          |
| ОНХС                                                     | 1           | 327.3          |               |          | 1               | 327.3          |          |          |          |          |
| ХХС                                                      | 1           | 58.3           |               |          | 1               | 58.3           |          |          |          |          |
| <b>Дүн</b>                                               | <b>4</b>    | <b>795.7</b>   | <b>0</b>      | <b>0</b> | <b>4</b>        | <b>795.7</b>   | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |                |               |          |                 |                |          |          |          |          |
| ОНХС                                                     | 1           | 210.5          |               |          | 1               | 210.5          |          |          |          |          |
| <b>Дүн</b>                                               | <b>1</b>    | <b>210.5</b>   | <b>0</b>      | <b>0</b> | <b>1</b>        | <b>210.5</b>   | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> |
| <b>Нийт дүн</b>                                          | <b>5</b>    | <b>1,006.2</b> | <b>0</b>      | <b>0</b> | <b>5</b>        | <b>1,006.2</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> | <b>0</b> |

### Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                 |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|-----------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Зөрчилгүй               | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс |
|   |                             |                          | Санал дүгнэлт               | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                 |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10              |
| 1 | ТШЗ                         | 4                        | 1                           | 3                  |                 | 1                       | 0              | 0     | 0               |
| 2 | Төсөл, хөтөлбөр             | 0                        |                             |                    |                 |                         |                |       |                 |
| 3 | ЗГТС                        | 0                        |                             |                    |                 |                         |                |       |                 |
| 4 | ТТЗ                         | 1                        | 1                           |                    |                 |                         | 1              |       |                 |
| 5 | ТЕЗ                         | 0                        |                             |                    |                 |                         |                |       |                 |
|   | НИЙТ                        | 7                        | 2                           | 3                  | 0               | 1                       | 1              | 0     | 0               |